



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
Т.ДОРЖХАНД ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.11.27 № 44

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ын 3.2.2.7-д "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх, иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, компани, шударга өрсөлдөөн, монопол, хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно" гэж туссан бөгөөд 2003 онд батлагдсан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, биелэлтийг хянан шалгах болон холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т "... хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно" гэж заасны дагуу Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд хийсэн үр дагаврын үнэлгээний талаарх мэдээлэл;

2.Үндэсний бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, өрсөлдөх чадвар, хэрэглээний аюулгүй байдлыг дээшлүүлэх, экологийн аюулгүй орчныг бүрдүүлэх, хэрэглэгчийг чанартай, аюулгүй бүтээгдэхүүнээр хангахад чиглэсэн ажлууд, түүний үр дүн /сүүлийн 5 жилийн байдлаар/;

3.Хэрэглэгчийн эрх түгээмэл хөндөгддөг салбар, түүнд гарсан чанарын өөрчлөлт болон хэрэглэгчийн эрх зөрчигдсөн асуудалд тавих хяналт, зөрчлийг арилгахад чиглэсэн арга хэмжээний талаар;

4.Хэрэглэгчийн мэдлэг, хэрэглээний соёлыг дээшлүүлэх чиглэлээр хийгдсэн сургалт, сурталчилгааны ажлын тоо, чанар, хэрэглэгчдийн боловсролын түвшингийн талаар;

5.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааны сайжруулалт, хүний нөөцийн чадавхын талаар;


6.Хэрэглэгчдээс ирүүлсэн өргөдөл гомдлын тоо, түүний шийдвэрлэлт, хэрэглэгчийн эрхийг хохироосон болон хууль зөрчсөн аж ахуй нэгж, тэдгээрт хүлээлгэсэн захиргааны хариуцлагын дүн болон бусад эдийн засгийн үзүүлэлтийн талаар;

2024000075

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН



Б.БАТ-ЭРДЭНЭ

2024000075